



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/80

Арвайхээр

Сургалт зохион байгуулах тухай

“Боловсролын тухай” хуулийн 8.2, Боловсрол Соёл Шинжлэх Ухааны сайдын 2007 оны 362 дугаар тушаалаар батлагдсан “Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр сургалт явуулах журам”-ын 2.1.2, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 2/01 дүгээр тогтоолоор батлагдсан Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “Бүтээлч Арвайхээр” хөтөлбөрийн 1.2.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2017-2018 оны хичээлийн жилд дүйцсэн хөтөлбөрөөр боловсрол нөхөн олгох 2 дугаар шатны танхимын сургалтын бага боловсролын холимог бүлгийн хичээлийг сумын Насан туршийн боловсролын сургалтын танхимд 2018 оны 4 дүгээр сарын 09-ны өдрөөс, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хичээлийг Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийг түшиглэн 2018 оны 4 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу тус тус зохион байгуулахыг сумын Насан туршийн боловсролын арга зүйч (Б.Пүрэвжаргал), сургалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж хамтран ажиллахыг Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн захирал (А.Очирбал) нарт тус тус үүрэг болгосугай.

2. Дүйцсэн хөтөлбөрийн бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтанд хичээл заах багш нарыг хавсралтаар баталж, багш бүртэй гэрээ байгуулан ажиллахыг сумын Насан туршийн боловсролын арга зүйч (Б.Пүрэвжаргал)-д даалгасугай.

3. Насан туршийн боловсролын сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Т.Чинзориг)-д, сургалтад хичээл заасан багшийн цагийн хөлс болон холбогдох бичиг хэргийн зардлыг тухай бүр зохих зардлаас тооцон олгохыг Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн Нягтлан бодогч (Б.Батчимэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.ПҮРЭВДОРЖ

371100153

Сумын Засаг даргын 2018 оны  
 05 дугаар сарын 02 ны /ний/ өдрийн 1/80  
 дугаар /дүгээр/ захирамжийн хавсралт

ДҮЙЦСЭН ХӨТӨЛБӨРИЙН СУРГАЛТАНД ХИЧЭЭЛ ЗААХ  
 БАГШ НАРЫН НЭРС

Д/д	Багшийн овог, нэр	Заадаг хичээлийн нэр	Мэргэших сургалтанд хамрагдсан эсэх	Дүйцсэн хөтөлбөрийн сургалтанд багшилж буй жил	Хичээл заадаг сургалтын нэр	
1.	Ц.Загарзүсэм	Монгол хэл- монгол бичиг	+	5	Бүрэн дунд, суурь	
3.	Д.Нарангэрэл	Уран зохиол	+	5	Бүрэн дунд, суурь	
5.	Н.Бат-Очир	Физик	+	6		
6.	Б.Цэрэн	Хими - биологи	+	3	Суурь, бүрэн дунд	
7.	А.Мөнххорол	НТМэдлэг, Түүх- иргэншил	+	5		
8.	Ц.Анхбаяр	Газар зүй	+	4		
9.	А.Гансүх	Технологи	+	4		
10.	М.Пүрэвсүрэн	Биеийн тамир	+	2		
11.	Л.Даваацэрэн	Англи хэл	+	3	Бүрэн дунд	
12.	Д.Дуламсүрэн	Орос хэл	+	4	Суурь, бүрэн дунд	
13.	Н.Дуламсүрэн	Мэдээлэл зүй	+	4	Бүрэн дунд	
14.	П.Баярцэцэг	Монгол хэл	+	3	Суурь	
15.	Т.Нарантуяа	Математик	+	3		
16.	Н.Гүрханд	Уранзохиол	+	2		
17.	Д.Баасанжаргал	Мэдээлэл зүй	+	2		
18.	Ц.Оюунчимэг	Англи хэл	+	2		
19.	Б.Пүрэвжаргал	Амьдрах ухаан	+	4		
20.	Д.Цэрэнханд	Бага анги	+	6		Бага боловсрол